

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН 2017 ОНЫ ТАНИЛЦУУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ

2018 он

АГУУЛГА

ОРШИЛ

НЭГ. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1 Эрчим хүч**
- 1.2 Зам тээвэр**
- 1.3 Харилцаа холбоо**
- 1.4 Аялал жуулчлал**
- 1.5 Аж үйлдвэр**
- 1.6 Барилга**
- 1.7 худалдаа, үйлчилгээний салбар**

ХОЁР. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

- 2.1 Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт**
- 2.2 Барилга**
- 2.3 Худалдааны салбар**
- 2.4 Тээвэр**
- 2.6 Харилцаа холбоо**
- 2.7 Бизнес регистрийн сан**
- 2.8 Дотоодын нийт бүтээгдэхүүн**

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Ашигласан материал

ОРШИЛ

“Говьсүмбэр аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбар” танилцуулгад аймгийн нутаг дэвсгэрт үйлдвэр, барилга, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгон авч зах зээл дээр эзлэх байр суурийн талаарх мэдээллийг оруулж өглөө.

Аймгийн эдийн засаг, дэд бүтцийн үндсэн үзүүлэлтүүдээр нэгдсэн танилцуулга бэлтгэж, тэдгээр үзүүлэлтэд гарсан өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг тодорхойлж орон нутгийн удирдлагыг дэлгэрэнгүй мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

Аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлэхэд нөөц боломжийг хэрхэн ашиглах ,улс,бүс нутгийн түвшинд эзэлж буй байр суурь , цаашдын чиг хандлагыг тодорхойлоход **судалгааны зорилго** оршино.

Аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбар нь Говьсүмбэр аймгийн голлох салбар мөн бөгөөд цаашид энэ салбаруудын аймгийн ДНБ-д нөлөөлөх нөлөөлөл, хандлагыг нэмэгдүүлэх, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулалт хийх, аймгийн хөгжлийн индексээр эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, түүгээр зогсохгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг мэдээнд бүрэн хамруулах нь цаг үеийн тулгамдсан асуудлыг нэг болж байна.

НЭГ.АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ

САЛБАРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Говьсүмбэр аймаг нь 1991 онд Улсын бага хурлын 46-р тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр сум, Шивээговь хороо, Улаанбаатар хотын Баянтал хорооны хилийн цэсээр Чойр хот болон байгуулагдсан ба 1994 онд Улсын их хурлын 32-р тогтоолоор Говьсүмбэр аймаг болсон. Манай аймаг нь Монгол Улсын төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт 557.0 мянган га нутаг дэвсгэртэй, зүүн болон төвийн бүсийн 4 аймгийн 9 сумтай хиллэдэг. Нийслэл Улаанбаатар хотоос 230 километрт байрладаг. Мөн олон улсын төмөр зам, автозамын сүлжээ, агаарын замын коридори дайран өнгөрдөг, цахилгаан

эрчим хүчний сүлжээнд бүрэн холбогдсон, өндөр хурдны шилэн кабельтай зэрэг хөгжих нөөц боломжоор хангагдсан аймаг юм.

1.1. Эрчим хүч. Цахилгааны эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй. Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХКомпаний Говьсүмбэр салбар нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Баянтал, Шивээговь, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг, Иххэт, Хэнтий аймгийн Дархан, Бор-Өндөр гэсэн 12 сум, суурин газрууд, Бор-Өндөрийн УБҮ, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, МАК ХХК-ийн Хөх цав цементийн үйлдвэр, Элдэвийн уурхай гэх мэт томоохон үйлдвэр, уурхайнуудыг цахилгаан эрчим хүчээр хангаж, 1007.4км цахилгаан дамжуулах агаарын шугам, 27.4 км кабель шугам, 176 ком дэд станцуудын тоног төхөөрөмжийн ашиглалт засвар, үзлэг үйлчилгээ, байнгын бэлэн байдлыг хангуулан ажилладаг. Нийт 657 аж ахуйн нэгж байгууллага, 7569 айл өрхтэй аж ахуйн гэрээ байгуулан, цахилгаан эрчим хүчээр хангаж, борлуулалтын үйл ажиллагааг эрхэлж байна.

Аймгийн дулааны эрчим хүчийг “УС-ДУ” ОНӨААТҮГазар, “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГазар, “Талын илч” ОНӨААТҮГазар, “Илчит сансар” ХХК зэрэг 4 аж ахуйн нэгж үйлдвэрлэж, 1500 орчим айл өрх, албан байгууллагыг дулаанаар хангаж байна.

1.2 Зам тээвэр. Говьсүмбэр аймгийн бүх сумдын нутгаар Москва-Улаанбаатар-Бээжинг холбосон Транс Сибирийн олон улсын транзит төмөр зам, авто замын босоо тэнхлэгийн засмал зам дамжин өнгөрдөг. Мөн олон улсын агаарын тээврийн коридор дайран өнгөрдөг. Тус аймгийн Баянтал суман дахь ачаа тээврийн болон иргэний зорчигч тээвэрлэх бүх төрлийн даацын онгоц хөөрч буух зориулалттай 3 км урт, 72 м өргөн 2 зурвас бүхий аэродром, тус бүрт нь 2 сөнөөгч онгоц багтах хэмжээ бүхий 44 ш ангарыг агуулахын зориулалтаар ашиглаж, олон улсын ачаа тээвэр, дамжуулан өнгөрөөх ложистик төвийн зориулалтаар ашиглахаар боломжтой юм. Мөн тус сум руу олон улсын төмөр замаас татсан салаа төмөр зам бий. Говьсүмбэр аймгийн Баянтал суман дахь тус аэродромыг ашигласнаар азиас европ, барууны орнуудад хийгдэж буй ялангуяа усан зам буюу далайн тээвэр зуучлалыг хөнгөвчлөх боломжтой болохын зэрэгцээ олон улсын тээврийн ложистикийн нэгдсэн сүлжээний бүрэлдэхүүн хэсэг болж, Монгол улс энэ салбарт өрсөлдөх чадвараа дээшлүүлэх боломжтой болно гэж үздэг.

Говьсүмбэр аймаг дахь автотээврийн төв нь аймаг доторхи такси үйлчилгээ эрхлэгч “Сүмбэр хас” ХХК, “Монгол шуудан” ХХК, “Чойрын гал” БГБХН, “Чойрын хүлэг” ХХК гэсэн 4 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдэд бүртгэлтэй 90 тээврийн хэрэгслээр зорчигч тээврийн үйлчилгээг үзүүлж байгаагаас 60 хувь нь такси үйлчилгээний 5122:2013 стандартыг хангасан.

“Хараацайн жигүүр” ХХК нь том оврын автобусаар, “Очирмөнх хайрхан” ХХК 15 таксигаар Улаанбаатар-Говьсүмбэрийн хооронд зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлж байна.

Жил тутам тээврийн хэрэгслийн тоо өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан аймгийн төвдөө хатуу хучилттай 8.2 км автозам тавьж, 22 км замыг гэрэлтүүлэгтэй, 14400 кв.метр автомашины зогсоолтой болсон байна.

1.3 Харилцаа холбоо. Говьсүмбэр аймаг нь Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл татагдсан өндөр хурдны шилэн кабельд холбогдсон. Интернет, утсан ба үүрэн телефоны үйлчилгээ бүрэн нэвтэрсэн, аймгийн төв болон сумдад орчин үеийн техник технологиор бүрэн тоноглогдсон Мобиком, Скайтел, Жи-Мобайл, Юнител компаниудын салбарууд үүрэн телефон, интернетийн үйлчилгээ явуулж байна. МЦХ-ны Говьсүмбэр салбар, “Сүмбэр кабель” ХХК, Юнивейшн зэрэг нь кабелийн телевизийн үйлчилгээг айл өрхөд үзүүлж байна. 2017 онд шинээр “Залуус” телевиз үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

1.4. Аялал жуулчлал. Говьсүмбэр аймаг нь Улаанбаатар хотоос 230 км алсад байрлах бөгөөд байгалийн үзэсгэлэнт газруудтай. Аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж бүхий аймаг юм.

Эдгээрээс дурьдвал Чойрын богд уулыг нэрлэж болох юм. Тус ууланд аргаль, чоно, үнэг, хярс, туулай, тарвага, цармын бүргэд, идлэг шонхор зэрэг амьтад байдаг. Мөн Зүүн жанжин Чойрын хийдийн туурь, Дагвасүндэл бурхан, Цагаандарь эх бурхан, Хүслийн хад, Хүүхдийн овоо, Шарав арилд бурхан, эртний хятадын төмөр утасны хорооны туурь, Дугар мээрэнгийн хөшөө зэрэг түүх,соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууд бий.

Сүүлийн жилүүдэд Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн шүүрүүлгийн уснаас бий болгосон Шивээгийн булгийн нууранд бух сугас загас үржүүлж байна.

Түүнчлэн гадаад, дотоодын аялагчдын сонирхлыг ихээр татах болсон Дорноговь аймгийн Хамрын хийд, Дундговь аймгийн Их,Бага газрын чулуу,Хэнтий

аймгийн Аварга тосонгийн рашаан, Чингисийн хөдөө арал зэрэг түүх,соёлын дурсгалт болоод байгалийн үзэсгэлэнт газруудын төвд оршдог.

Боржигин түмний өлгий нутаг, боржигин өв соёлоо сэргээх, өвлүүлэх ажлуудыг эрчимтэй хийж байгаа нь аялагчдын сонирхлыг татах бас нэгэн хөшүүрэг болох юм.

Хэдийгээр аялал жуулчлалын салбар төдийлөн хөгжөөгүй ч Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт аялал жуулчлалыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр тусгасан байна.

1.5 Аж үйлдвэр. Говьсүмбэр аймаг нь сүүлийн жилүүдэд эдийн засгийн хувьд эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд нүүрсний уурхай, жонш боловсруулах үйлдвэр, ноос угаах үйлдвэр, төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр, ган бөмбөлгийн үйлдвэрүүд үйл ажиллагаа эрхэлж байна.

Улсын хэмжээний томоохон нүүрсний уурхай болох “Шивээ-Овоо” ХКомпаний нүүрсний орд нь 29500.0 га талбайг хамардаг. Б-2 бүлгийн хүрэн нүүрсний 2708.7 сая тонн нүүрсний нөөцтэй, далайн түвшнээс дээш 1180-1220 м-т оршдог. Тус орд нь нүүрсний 8 давхаргаас тогтдог. Одоогоор зөвхөн 1,2-р давхарт олборлолт явуулж байна. Олборлосон нүүрсний дундаж илчлэг нь 3010-3020 кКал, чийглэг нь 40% байгаа нь өнөөгийн мөрдөж буй технологийн стандартыг хангаж байгаа юм.

Шивээ-Овоогийн уурхай нь олборлолт борлуулалтын хэмжээгээрээ Багануурын нүүрсний уурхайн дараа 2-рт ордог ба Монгол улсын нүүрсний 2 дахь том уурхай бөгөөд улсын хэмжээнд олборлож буй нүүрсний 30%-ийг дангаараа гаргаж, жилдээ 1,3 сая тн нүүрс олборлон нийт нүүрснийхээ 80 гаруй хувийг ТЭЦ-4-д нийлүүлж, МУ-ын төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангахад гол үүрэг гүйцэтгэж байна.

Шивээ-Овоогийн уурхай нь Япон, ОХУ, АНУ зэрэг орнуудын дэвшилтэт техник технологиудаар үйлдвэрлэлээ явуулж байна. Тус уурхайг түшиглэн химийн боловсруулах үйлдвэр барих бүрэн боломжтой.

1.6 Барилга.

Аймгийн хэмжээнд барилга угсралт, засвар, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилт, цахилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй **9** аж ахуй нэгж байгууллага байна. Үүнд:

Барилга угсралт, засвар, шугам сүлжээний чиглэлээр:

1."Хүрийн хотхон"ХХКомпани – Захирал н.Цогбадрах, утас: 91911486

2. “Чойр хайрхан”ХХКомпани – Захирал Л.Одбаясгалан, утас: 99084201
3. “Илчит Сансар”ХХКомпани – Захирал С.Лувсанвандан, утас: 99542115
4. “Жавхлант-Арвижих”ХХКомпани- Захирал Б.Баттүвшин, утас: 88008979
5. “Сүмбэр гүн”ХХКомпани – Захирал П.Бадамцэцэг, утас:88549094
- 6.”Энхжих формат” ХХКомпани – Захирал Ш.Билэгзүмбэрэл, утас: 99275975
- 7.”Ус-Ду”ОНӨААТҮГазар – Захирал Б.Ганзориг, утас: 99908737
8. “ ОСО-КОНСТРАКШН”ХХК – Захирал Д.Отгонбаяр, утас:99014551
- 9.”Оч хийц”ХХКомпани –Захирал Д.Оюун, утас:94198989

- **Гадна тохижилтын ажлын чиглэлээр:**

- 1.”Оч хийц”ХХКомпани – Захирал Д.Оюун, утас:94198989

- **Цахилгааны ажлын чиглэлээр:**

1. “ОСО-КОНСТРАКШН”ХХК – Захирал Д.Отгонбаяр, утас:99014551

ХОЁР.СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индексийн тооцоонд Үндэсний Статистикийн Хорооны бизнес регистрийн санд бүртгэлтэй аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана.

Эдийн засгийн бүх төрлийн ажиллагааны салбарын ангиллын дагуу аж үйлдвэр нь дотроо уул уурхай, олборлох аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж гэсэн 3 салбарт хуваагдана.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар нь дотроо 4 дэд салбарт, боловсруулах аж үйлдвэрийн салбар нь дотроо 21 дэд салбарт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбар дотроо 2 дэд салбарт мөн ангилагдана.

Энэхүү ангилал нь эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын тухайн үед хэрэглэгдэж буй хувилбарын дагуу өөрчлөгдөж болно.

Үйлдвэрлэл: Тухайн аж ахуйн нэгжийн зах зээлд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг хэлнэ.

Борлуулалт: Тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ.

Аймаг орон нутгийн хувьд аж үйлдвэрийн салбарыг төлөөлж чадахуйц томоохон аж ахуйн нэгжүүдийг сонгон авч энэхүү судалгааг хийдэг. Манай аймгийн хувьд аж үйлдвэрийн мэдээг “Шивээ-Овоо” ХК 1993 оноос, Тохижилт сүмбэр ОНӨҮГ, УС-ДУ ОНӨҮГ газруудаас 2004 оноос, Илчлэг Шивээ ОНӨҮГ, Талын –Илч ОНӨҮГ 2008 оноос, Илчит Сансар ОНӨҮГ 2012 оноос эхлэн авч, хянан нэгтгээд Үндэсний статистикийн хороонд дамжуулахаас гадна танилцуулга, судалгаанд ашиглаж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний биет хэмжээг нэгтгэн гаргах мэдээллийн эх үүсвэр нь **“Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн сарын мэдээ” / АҮ-1 /**, үйлдвэрлэгчийн үнийн индекс тооцох мэдээллийн эх үүсвэр нь **“Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн сарын мэдээ” / АҮСҮҮМ-1 /**, индексийн тооцоонд ашиглах жинг тооцох мэдээллийн эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын дүн, бизнес регистрийн сангийн холбогдох зүүллэлт, аж үйлдвэрийн салбарын жилийн эцсийн мэдээ **/ АҮ-7 /** байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэр:

Энэхүү салбарыг онолын үүднээс авч үзвэл: Газрын гүнээс болон өнгөн хэсгээс хатуу, шингэн, хийн хэлбэртэй байгалийн ашигт малтмал олборлох, түүнийг цэвэрлэх, бутлах, ялгах зэргээр анхны боловсруулалт хийх үйл ажиллагааг хамруулдаг салбар юм. Бидний хувьд үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хүрэн нүүрс олборлолт дээр тулгуурладаг “Шивээ-Овоо” ХХК энэ судалгаанд хамрагдана.

Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж:

Энэ салбарт халаалтын болон эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор уур, халуун ус үйлдвэрлэх, түгээх, хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд зориулж ус хуримтлуулан ариутгаж, түгээх үйл ажиллагаа хамрагддаг. Манай аймгийн хэмжээнд уг салбарт “УС-Ду” ОНӨААТҮГ, “Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ, “Илчлэг Шивээ” ОНӨААТҮГ, “Талын –Илч” ОНӨААТҮГ “Илчит Сансар” ХХК гэсэн байгууллагууд хамрагдаж байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн мэдээг “Шивээ-Овоо” ХК, “Ус-Ду” ОНӨААТҮГ, “Тохижилт Сүмбэр” ХХК, “Талын илч” ХХК, “Илчлэг Шивээ” ХХК, “Илчит сансар” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудаас авдаг бөгөөд эдгээр аж ахуйн нэгж байгууллагууд 2017 онд 52.2 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 54.1 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 10.9 хувиар өссөн ба үүнд уул, уурхайн салбарын үйлдвэрлэлт голлон нөлөөлсөн байна. Бүтээгдэхүүн борлуулалт өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар өслөө.

“Шивээ-Овоо” ХК нь тайлант онд 46.9 тэр бум төгрөгийн нүүрс үйлдвэрлэж, 49.2 тэр бум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 3.9 хувиар, бүтээгдэхүүн борлуулалт 15.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Тус компани нь аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 89.8 хувийг, нийт борлуулалтын 91 хувийг гүйцэтгэсэн бөгөөд зах зээл дээр 1 тонн нүүрсийг 24220-27380 төгрөгөөр худалдаалсан байна.

Аймгийн хэмжээний төв суурин газруудад халаалт, халуун хүйтэн ус үйлдвэрлэх, бохир ус татан зайлуулах чиглэлээр Ус-Ду, Талын Илч, Илчлэг Шивээ, Илчит сансар зэрэг аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2017 онд нийт 2333.3 сая төгрөгийн үйлдвэрлэл явуулснаас 1852.5 сая төгрөгийн дулаан, 326,9 сая.төгрөгийн ус, 153,9 сая төгрөгийн сувагжуулалт хийсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт үйлдвэрлэл 19.5 хувиар үүнээс дулаан үйлдвэрлэл 9.6 хувиар, ус 76 хувиар, сувагжуулалт бараг 2 дахин тус тус нэмэгдлээ.

Боловсруулах үйлдвэр сүүлийн жилүүдэд хөгжиж байгаагаас “Чойр хайрхан”, “Чойр кашмер”, “Тэвшийн хажуу ус” хоршоо, Шивээ сервис зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудыг судалгаанд хамруулж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн гаргалт, сумдаар

/сая.төг/

Он	Баянтал	Сүмбэр	Шивээговь	Дүн
2005	-	224.1	10619.9	10844.0
2006	-	216.4	13601.7	13818.1

2007	-	302.7	12397.7	12700.4
2008	-	499.8	13810.6	14310.4
2009	-	401.1	13359.4	13760.5
2010	115.4	534.7	27562.4	28212.6
2011	118.2	569.3	24245.3	24932.8
2012	129.2	751.1	26747.5	27627.8
2013	147.6	853.2	32615.1	33484.0
2014	177.0	896.6	37102.4	38176.0
2015	240.0	1293.1	36026.4	37559.5
2016	232.0	1375.1	45456.5	47063.6
2017	3058.8.0	1825.8	47322.1	52206.7

2017 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт 52206.7 сая төг болж, 2016 оноос 5143.1 сая төг буюу 10.9 хувиар, 2010 оноос 23994.1 сая төг буюу 85 хувиар, 2005 оноос 413672.7 сая төг буюу 4.8 дахин өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, сая.төг	47063.6	52206.8	5039.4	110.9
Бүтээгдэхүүн борлуулалт, сая.төг	44862.2	54120.5	9258.3	120.6

“Шивээ-Овоо” ХК-ий бүтээгдэхүүн, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Бүтээгдэхүүн борлуулалт /үнийн дүнгээр/	сая.төг	42772.1	49245.5	6473.4	115.1

Нүүрс борлуулалт /биет хэмжээ/	мян.тн	1880.3	2023.9	143.6	107.6
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр/	сая.төг	45111.2	46879.9	1768.5	103.9
Нүүрс гаргалт /биет хэмжээ/	мян.тн	1961.4	2074.7	113.3	105.8
Нийт ажиллагсдын тоо	хүн	595	547	48	91.9

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл , дэд салбараар, оноор

Үзүүлэлтүүд	нийт дүн	уул уурхай	боловсруул ах үйлдвэр	дулааны эрчим хүч үйлдвэрл эл, усан хангамж
2016 оны I-XII үйлдвэрлэл сая төг	47063.6	45111.2	0.2	1952.2
2017 оны I-XII үйлдвэрлэл сая төг	52206.8	46879.9	2993.6	2333.3
2016 оны I-XII борлуулалт сая төг	44862.2	42772.1	137.9	1952.5
2017 оны I-XII борлуулалт сая төг	54120.5	49245.5	2779.9	2095.1

2.2. БАРИЛГЫН САЛБАР

Ойлголт, тодорхойлолт:

Барилга угсралтын ажил нь орон сууцны барилга, орон сууцны бус барилга, инженерийн байгууламж, их засварын ажлаас бүрдэнэ.

Орон сууцны барилгад хүн амьдран суух зориулалттай барилгыг, орон сууцны бус барилгад үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, зочид буудал, эмнэлэг, сүм хийд, сургууль, соёлын гэх мэт зориулалттай барилгыг, инженерийн байгууламжид эрчим хүч, холбоо, төмөр зам, авто зам, гүүр, гүүрэн гарц, далан суваг, шугам зэрэг байгууламжийг, их засварын ажилд орон сууцны, орон сууцны бус, инженерийн байгууламжид хийсэн их засварын ажлуудыг хамруулдаг.

Энэхүү танилцуулгад Говьсүмбэр аймагт барилгын салбарын гүйцэтгэсэн барилга угсралтын ажил (барилгын төрөл объектоор), ашиглалтад оруулсан барилга байгууламж, тэдгээрийн хүчин чадал, барилгын байгууллагын барилга угсралтын ажлын зардал зэрэг үзүүлэлтүүдийг оруулсан болно. Дээрх үзүүлэлтүүдийг барилгын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага болон аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс сар, улирал бүр авдаг мэдээллээр бүрдүүлдэг.

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас 2017 онд 37 барилгын угсралт, засвар, инженерийн шугам сүлжээний ажилд “Ажил эхлэх зөвшөөрөл” олгож, 15 барилга угсралт, засварын ажлыг ашиглалтад оруулсан байна. Шинээр ашиглалтад орсон барилга, байгууламжийг улсын төсөв, аймгийн орон нутгийн хөгжлийн сан, авто замын сан, Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс- Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр”-ийн хүрээнд санхүүжүүлэн гүйцэтгэж ашиглалтад оруулжээ.

Барилга угсралт, засварын чиглэлээр хувийн болон төрийн өмчөөр 31266.8 сая төгрөгийн ажил хийгдсэн байна. Дотоодын барилгын байгууллагууд 2427.1 сая төгрөгийн ажил гүйцэтгэжээ. Үйлдвэрийн болон төмөр замын барилга байгууламж баригдаагүй байна.

**БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, барилгын төрлөөр,
улирлаар, өссөн дүнгээр**

хэмжих нэгж: сая.төг

№	Барилгын төрөл	2017-I	2017-II	2017-III	2017-IV
1	Барилга угсралт, их засварын ажил	0	7766.4	18332.8	31266.8
2	Орон сууцны барилга	0	0	2712.0	6067.2
3	Орон сууцны бус барилга	0	2043.6	5681.6	7144.3
4	Үйлдвэрийн	0	0	0	0
5	Худалдаа, үйлчилгээний	11140.0	49861.4	91205.7	116876.4
6	Эмнэлэг, сургууль, соёлын	5322.4	73166.0	150566.9	197352.9
7	Бусад	4745.0	27759.5	40367.1	63921.4
8	Инженерийн барилга, байгууламж	8425.2	83862.9	118139.8	189221.4
9	эрчим хүчний	6832.1	50642.2	63273.2	90477.7
	холбооны	0	56551.8	91506.4	115295.1
	төмөр зам	0	0	0	0
	автозам	0	313.5	1352.0	1393.0
	гүүр, гүүрэн гарц	0	69.5	228.9	284.7
	далан ,суваг, шугам, сүлжээ	0	1292.2	11007.2	11819.7
	бусад	0	0	145.7	0
	их засварын ажил	0	231.8	1003.8	0

Эх сурвалж: ҮСХорооны барилга угсралт, их засварын улирлын мэдээ

**ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ
ЗАСВАРЫН АЖИЛ, сум аар**

хэмжих нэгж: сая.төг

	аймаг, сумын нэр	2017-I	2017-II	2017-III	2017-IV
1	Говьсүмбэр аймаг	0	231.8	1143.2	2427.1
2	Сүмбэр сум	0	168.2	908.8	2389.1
3	Баянтал сум	0	63.7	71.4	0
4	Шивээговь сум	0	0	163	38

Эх сурвалж: ҮСХорооны барилга угсралт, их засварын улирлын мэдээ

2017 онд ашиглалтад оруулсан барилга байгууламжийн жагсаалт

№	Барилга байгууламжийн нэр	Хэмжих нэгж (тухайн барилга байгууламжийн зориулалтаар)	Захиалагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр, регистрийн дугаар	Зураг төсөл гүйцэтгэсэн байгууллага нэр, регистрийн дугаар	Гүйцэтгэгч байгууллагын нэр, регистрийн дүгээр	Комиссын актын дугаар, огноо	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийт төсөвт өртөг мян/төг
1	Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн дотуур байрны засварын ажил	Фасад-1100 м2 дотор засвар-716 м2	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	Гранд тек ХХК РД:5208092	Гээт ХХК РД:5135281	2017.06.12 №2017/02	Япон улсын Засагийн газрын Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр	168,153,234
2	Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн гадна тохижилтын ажил	7200 м2	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	Өсөх Оргил прожект ХХК РД:5357179	Илчит Сансар ХХК РД:4612655	2017.06.12 №2017/03	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	116,588,888
3	Хэлмэгдэгсдийн хөшөөнөөс 4-н замын уулзвар хүртэлх авто замын дагуух гэрэлтүүлгийн ажил	98 Вт	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	-	Сүмбэр старлет ХХК РД:4612175	2017.07.05 №2017/04	Авто замын сан	11,600,000
4	Баянтал сумын Соёлын төвийн дээвэр засварын ажил	603.5 м2	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	-	Шүүдэр гранд ХХК РД:4270835	2017.07.06 №2017/05	Улсын төсөв	36,170,000
5	Нэгдсэн эмнэлгийн барилгын их засварын ажил	3310.1 м2	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	-	Гүнгийнхэн ХХК РД:4275314	2017.08.21 №2017/06	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	79,972,422
6	Нийтийн эзэмшлийн авто замын ажил	2202 м2	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	-	Борхойн зам ХХК РД:3307603	2017.08.22 №2017/07	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	139,426,174
7	Нийтийн эзэмшлийн явган замын ажил	1320 м2	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	-	Борхойн зам ХХК РД:3307603	2017.08.22 №2017/08	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	54,899,421

8	АЗДТГ-ын урд авто зогсоол байгуулах ажил	450 м2	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	-	Борхойн зам ХХК РД:3307603	2017.08.22 №2017/09	Авто замын сан	15,000,000
9	Хонхор хотхоны авто замын өргөтгөлийн ажил	700 м2	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	-	Борхойн зам ХХК РД:3307603	2017.08.22 №2017/10	Авто замын сан	20,000,000
10	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд гэрэлтүүлэг хийх ажил	100 Вт 24 ширхэг	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	Гэрэлт Ундрал Алтай ХХК РД:	Осо констракшн ХХК РД:4612248	2017.08.30 №2017/11	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	29,815,218
11	Нийтийн эзэмшлийн гудамж, тоглоомын талбайн тохижилтын ажил	2400 м2	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	Эй Эн И И ХХК РД:5172128	Өгөөмөрөн шанд ХХК РД:5629942	2017.09.05 №2017/12	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	75,846,359
12	Баянтал сумын 4-р сургуулийн спорт заалны барилга засварын ажил		Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945		Рашбай ХХК РД:4612655	2017.09.07 №2017/13	Улсын төсөв	35,195,845
13	Биеийн тамир, спортын газрын барилгын их засварын ажил		Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945		Илчит Сансар ХХК РД:4612655	2017.09.07 №2017/14	Улсын төсөв	74,567,899
14	Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын гадна дулаалга, фасадны ажил /1-р байр/	130 айл	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	-	Вилла бридж ХХК РД:5309999	2017.09.20 №2017/15	Орон нутгийн төсөв	184,585,051
15	Говьсүмбэр аймгийн төвийг теле камерын системд холбох ажил	50 ширхэг	Аймгийн Засаг даргын Тамгын газар РД:9018945	БСТ ХХК РД:5032368	БСТ ХХК РД:5032369	2017.09.25 №2017/16	Орон нутгийн төсөв	217,343,053

2.3. ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

Ойлголт, тодорхойлолт:

Худалдааны борлуулалт гэдэг нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын дүн бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно. Цэвэр борлуулалтыг тооцохдоо нийт борлуулалтаас борлуулалтын буцаалт, хөнгөлөлтийг хасна.

Энэхүү салбарын судалгааг гаргах мэдээллийн эх сурвалж нь худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн сар, улирлын тайлан (ХУ- 1а, ХУ-1б ,ХУ-1) болно.

Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь өөрсдөө үйлдвэрлэл явуулахгүй боловч үйлдвэрлэгчдээс бараа, материал худалдан авч, худалдан авсан бараагаа ямар нэгэн боловсруулалт хийхгүйгээр дахин худалддаг онцлогтой салбар юм.

Худалдааны байгууллагын үндсэн зорилго бол тухайн нутгийн ард иргэдийг найдвартай, чанарлаг, хүсэл сонирхолд нь нийцсэн бараа бүтээгдэхүүнээр үйлчлэхэд оршдог. Худалдааны байгууллагууд ихэнхдээ бөөний болон жижиглэн худалдаа дагнах эсвэл холимог хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэн явуулдаг.

Хүн амын өдөр тутмын болон өргөн хэрэглээний бараа, таваарыг бэлнээр худалдаж, хэрэглэгчдэд хүргэдэг цэгүүдийг худалдаа эрхэлдэг байгууллага гэнэ.

2005 оноос хойш жижиг мухлаг, ТҮЦ-ийн тоо жил тутам багасаж хүнсний дэлгүүр, "Super market"-ийн тоо нэмэгдэж байгаа нь аймгийн худалдааны салбарын хөгжлийг харуулж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны борлуулалт, улс, бүс, аймгийн дүнгээр,
оны үнээр , сая төгрөгөөр

Аймаг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Улсын дүн	2075.5	3855.8	9002.0	10620.0	11305.7	13526.6	13199.2	15629.1
Бүсийн дүн	176.3	269.3	314.1	310.7	322.4	335.2	355.1	444.04
Дорноговь	27.1	36.2	51.5	31.3	34.8	56.1	57.1	59.7
Дундговь	6.5	14.2	12.9	14.6	18.7	21.4	25.5	25.01

Өмнөговь	43.2	100.3	70.4	57.8	54.3	60.8	86.6	117.8
Сэлэнгэ	1.6	7.2	10.2	13.3	10.6	17.6	19.6	21.99
Төв	18.5	23.1	23.2	15.1	20.8	18.4	15.9	21.8
Дархан-Уул	52.4	55.2	96.6	104.4	145.6	139.6	122.2	148.5
Говьсүмбэр	27.1	33.1	49.4	74.3	37.7	21.3	28.1	49.23

Зочид буудлын салбарын орлого, улирлаар, өссөн дүнгээр, улс, бүс, аймгаар, сая төгрөгөөр

улс, бүс, аймаг	2017-I	2017-II	2017-III	2017-IV
улсын дүн	19416.3	59243.1	112577.1	151922.5
Төвийн бүс	1272.5	4307.1	6587.2	8978.9
Говьсүмбэр	57.3	95	151	231.5

Нийтийн хоолны салбарын орлого, улирлаар, өссөн дүнгээр, аймгаар, мянган төгрөгөөр

улс, бүс, аймаг	2017-I	2017-II	2017-III	2017-IV
улсын дүн	55800.5	127099.9	224724.0	298778.3
Төвийн бүс	2044.5	4528.9	6371.9	9013.4
Говьсүмбэр	220.1	514.2	761.4	1182.7

2017 онд худалдааны борлуулалт улсын дүнгээр 15629 сая төг болж 2016 оноос 2429.8 сая төг буюу 18.4 хувиар өссөн байна.

Төвийн бүсийн худалдааны борлуулалт 2017 онд 444.04 сая төг болж 2016 оноос 88.9 сая төг буюу 25 хувиар өсөхөд худалдааны борлуулалт Өмнөговь аймагт 31.2 сая төг 36 хувь, Говьсүмбэр аймагт 21.13 сая төг буюу 75 хувиар өссөн нь голлон

нөлөөлсөн байна. Говьсүмбэр аймагт бөөний болон жижиглэн худалдааны борлуулалт 2010-2013 онуудад тогтвортой өсч, 2014-2015 онуудад буурч байсан бол 2016-2017 онд өссөн үзүүлэлттэй байна.

Зочид буудлын орлого төвийн бүсийн 2.6 хувийг, нийтийн хоолны салбарын орлого 13.12 хувийг эзэлж байна.

2.4. ТЭЭВЭР

Ойлголт, тодорхойлолт:

Зорчигч эргэлт: Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

Тээврийн орлого: Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр байна. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.

Говьсүмбэр аймгийн Авто тээврийн төвийн мэдээ, онуудаар

	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014он	2015он	2016он	2017он
Зорчигч эргэлт	мян.хүн.км	2332.6	2930.6	3359.0	5304.0	5355.2	5456.6
Тээсэн зорчигч	мян.хүн	10,6	12,2	14.0	22.1	23.87	25.31
Тээврийн орлого	мян.төг	8624.9	7058.7	8044.5	12112.1	14200	15439.4
Ажиллагчдын тоо	хүн	7	9	8	10	12	11

Тээвэр, авто замын газрын мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал зорчигч эргэлт 101.4 мян.хүн.км буюу 1.8 хувиар, тээсэн зорчигч 1.44 мян.хүн буюу 6 хувиар, тээврийн орлого 1239.4 мян төг буюу 8.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбарын мэдээгээр 2017 оны байдлаар 3505 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэний 2135 нь суудлын, 817 нь ачааны, 269 нь хоёр дугуйт, 284 нь тусгай зориулалтын болон бусад тээврийн хэрэгсэл байна.

2017 оны байдлаар 3505 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 458 буюу 15 хувиар өссөн байна. Тээврийн хэрэгслийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал суудлын авто машин 21.4 хувиар, хоёр дугуйт 30 хувиар, тусгай болон бусад тээврийн хэрэгсэл 16,9 хувиар өсч, ачааны автомашин 2,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тээвэр зуучлал, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Зорчигч эргэлт	мян.хүн.км	5355.2	5456.6	101.4	101.8
Тээвэрлэсэн зорчигч	мян.хүн	23.9	25.31	1.41	105.9
Тээврийн орлого	мян.төг	14200	15439.4	1239.4	108.7
Ажиллагчдын тоо	хүн	11	11	0.0	100.0

Тээврийн хэрэгсэл, харьцуулсан үзүүлэлтээр

Төрөл	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Суудлын автомашин	1759	2135	376	121.4
Ачааны автомашин	838	817	-21	97.5
Хоёр дугуйт	207	269	62	130.0
Бусад	243	284	41	116.9
Бүгд	3047	3505	458	115.0

Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо, улс, бүс, аймгаар

Аймаг	2012 он	2013 он	2014 он	2015он	2016он	2017 он
Улсын дүн	345473	384864	437677	482049	499152	536399
Төвийн бүс	39757	44509	47811	50119	54206	60425
Дорноговь	6888	7632	8314	8406	9268	11155
Дундговь	3353	3112	3385	3144	2961	2954
Өмнөговь	8056	10383	11244	11769	13441	16487
Сэлэнгэ	6677	6750	7090	7640	8404	10403
Төв	5488	5906	6996	7810	8138	7941
Дархан –уул	8237	9506	9177	9485	9725	9152
Говьсүмбэр	1058	1220	1605	1865	2269	2333

Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо, төрлөөр, төвийн бүсийн аймгийн дүнгээр

Аймаг	2017 он	Үүнээс			
		Суудлын	Ачааны	автобус	Тусгай зориулалтын
Дорноговь	11155	7652	2767	424	312
Дундговь	2954	1770	895	226	63
Өмнөговь	16487	8348	6700	755	684
Сэлэнгэ	10403	6237	3769	319	78
Төв	7941	4009	3600	285	47
Дархан –уул	9152	6188	2489	353	122
Говьсүмбэр	2333	1673	523	74	63

Техникийн үзлэгт хамрагдсан автомашины тоо, ашигласан хугацаагаар, улс, бүс, аймгаар

Аймаг	2017он	үүнээс		
		0-3 жил	4-9жил	10-аас дээш жил
Улсын дүн	536399	9981	104075	422343
Төвийн бүс	60425	500	10053	49872
Дорноговь	11155	99	1339	9717
Дундговь	2954	14	233	2707
Өмнөговь	16487	254	5349	10884
Сэлэнгэ	10403	50	1152	9201
Төв	7941	18	587	7336
Дархан –уул	9152	44	1080	8028
Говьсүмбэр	2333	21	313	1999

2.5. ХАРИЛЦАА ХОЛБОО

Ойлголт, тодорхойлолт:

Суурин телефон цэг : Нийтийн телефон сүлжээнд хэрэглэгчийн шугамаар телефон станц дээр порт эзлэн зориулалтын төхөөрөмжөөр холбогдсон эцсийн хэрэглэгчийг хэлнэ.

Интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллага: Харилцаа холбооны зохицуулах хорооноос интернетийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан эрх бүхий байгууллагыг хэлнэ.

Интернет кафе: олон нийтэд нэг цэгт интернетийн үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээний цэг.

Аймгийн холбооны газрын 2017 оны мэдээгээр үйлчилгээний нийт орлого 156.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 46.2 сая төгрөг буюу 22.8 хувиар буурч, хүн амаас орсон орлого 93.7 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 27.8 сая төгрөгөөр бага буюу 22.8 хувиар буурсан байна. хэрэглэгчээс олсон орлого нь нийт орлогын 60 хувийг бүрдүүлсэн эв өмнөх оны түвшинд байна. Аймгийн хэмжээгээр КаТВ сувагт холбогдсон хэрэглэгч 866 байгаа нь өмнөх оныхоос 367 хэрэглэгчээр буюу 29.8 хувиар, телефон цэгийн тоо 285 байгаа нь өмнөх оны мөн үеэс 49 хэрэглэгчээр буюу 14.8 хувиар тус тус буурчээ.

2014-2017 оны жилийн эцсийн мэдээгээр

Үзүүлэлт	нэгж	2014	2015	2016	2017 он
Нийт орлого	Сая төг	224.7	220.2	202.4	156.2
Үүнээс:хүн амаас	Сая төг	134.8	121.5	121.5	93.7
КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч	Тоо	1295	1272	1233	866
Телефон цэг	Тоо	403	387	334	285

Харилцаа холбоо, харьцуулсан үзүүлэлтээр

Үзүүлэлт	ХЭМЖИХ нэгж	2016 он	2017 он	Өөрчлөлт	Хувь
Нийт орлого	мян.төг	202478	156200	-46278	-22.8
Үүнээс: Хүн амаас	мян.төг	121583.6	93700	-27883,6	-22.9

КАТВ-ийн сувагт						
холбогдсон	тоо	1233	866	-367	-29.8	
хэрэглэгч						
Телефон цэг	тоо	334	285	-49	-14.7	

2017 онд интернет үйлчилгээний цэгийн тоо 2 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2.6. БИЗНЕС РЕГИСТРИЙН САН:

Ойлголт, тодорхойлолт:

Бизнес регистр: Тодорхой бүтэцтэй, тогтмол шинэчлэгдэн статистикийн зорилгоор ашиглалгддаг аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл юм. Тус санд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжүүдийн статистикийн мэдээллийг хамруулна. Статистикийн бизнес регистрийн санг аж ахуйн нэгү байгууллагын 1998 оны анхны тооллогын дүнд үндэслэн байгуулж, 2006, 2011, 2016 оны тооллогын дүн, мэдээллийн бусад эх үүсвэрээс тогтмол баяжуулж байна.

Улсын хэмжээнд 2017 онд 155.1 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 78.6 (50.7%) мянга нь үйл ажиллагаа явуулж байна. Бизнес регистрийн санд ботгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын 50.5 мянга нь Улаанбаатар хотод, 9.0 мянга нь төвийн бүс, 8.7 мянга нь Хангайн бүс, 7.1 мянга нь Баруун бүс, 3.3 мянга нь Зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байна.

2017 оны эцсийн байдлаар Говьсүмбэр аймагт 439 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагийн 302 (68.8%) аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн, нэгж, байгууллага, улс, бүс, аймгаар, ажил эрхлэлтийн байдлаар

Үзүүлэлт	бүгд	үйл ажиллагаа явуулж байгаа	үйл ажиллагаа явуулаагүй	эхлээгүй	түр зогсоосон	бүрэн зогсоосон	бусад
Улс	155065	78585	76480	38149	34204	1570	2557
Төвийн бүс	13804	9050	4754	2371	1979	320	84

Говьсүмбэр	439	302	137	45	39	53	-
------------	-----	-----	-----	----	----	----	---

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр

	өмчийн хэлбэр /2017-IV /
Төрийн өмчийн	45
хувийн	238
хувийн хамтарсан	3
гадаад улсын	1
орон нутгийн өмчийн	15
Бүгд	302

2.7. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Ойлголт, тодорхойлолт: Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тодорхой хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нэмэгдэл өртгийн нийт хэмжээ юм. Дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний нийт орлогын анхдагч мэдээллийн эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын албан ёсны жилийн тайлан тэнцэл, түүнд тусгагдсан үзүүлэлтүүд болно. ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцно. Нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг үйлдвэрлэлийн; эцсийн хэрэглээ, хуримтлал, цэвэр экспортын нийлбэрээр тодорхойлохыг эцсийн ашиглалтын; хөдөлмөрийн хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, үйлдвэрлэл болон импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг, холимог орлого зэрэг орлогын элементийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ. Үндэсний нийт орлого (ҮНО)-ыг тухайн улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нэмэгдэл өртгийн нийт дүнгээр тодорхойлно. ДНБ дээр гадаад эдийн засгаас орж ирсэн цэвэр орлого буюу эдийн засгийн харьяатаас орж ирсэн орлогыг нэмж, тус улсын харьяат бусын орлогыг хасч ҮНО-ыг тооцно. Гадаад эдийн засгаас орж ирэх орлогод эдийн засгийн харьяат, харьяат бусын хооронд хийгдэх хоёр төрлийн ажил г үйлгээ байх ба энэ нь харьяат бус

ажиллагчдад төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, гадаад хөрөнгө оруулалтын орлого байна. Уг мэдээ нь Монгол улсын төлбөрийн тэнцэлд тусгана.

Дотоодын нийт бүтээгдэхүүн, улс,бүс, аймаг, жилээр

	2016 он	2017 он
Улс	23935853.7	23942866.4
Төвийн бүс	2431818.5	2439043.8
Дорноговь	258496.9	272888.4
Дундговь	224032.3	226072.5
Өмнөговь	411055.7	404035.8
Сэлэнгэ	562626.7	555423.0
Төв	508343.1	510608.8
Дархан-Уул	386883.5	387260.4
Говьсүмбэр	80380.3	83354.9

Хэмжих нэгж: сая төг

Дотоодын нийт бүтээгдэхүүн, улс,бүс, аймаг, салбараар

	ДНБ,сая төг	дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	үйлчилгээ
Улс	23942866.4	11.5	36.6	51.8
Төвийн бүс	2439043.8	29.7	35.2	35.2
Дорноговь	272888.4	25.6	18.1	56.4
Дундговь	226072.5	55.1	14.1	30.7
Өмнөговь	404035.8	22.5	42.9	34.7
Сэлэнгэ	555423.0	23.9	48.1	28.0
Төв	510608.8	49.4	27.6	23.0
Дархан-Уул	387260.4	9.7	42.1	48.2
Говьсүмбэр	83354.9	20.0	38.3	41.7

Аймгийн ДНБүтээгдэхүүн 2017 онд өмнөх оныхоос 2974.6 сая төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна. ДНБ-ий 41.7 хувийг үйлчилгээний салбар, 38.3 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 20 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байна.

ДҮГНЭЛТ

Аж үйлдвэрийн салбар бол манай аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг юм. Ер нь аливаа улс орны эдийн засгийн хөгжлийг ДНБ-ний өсөлт, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээр тодорхойлохоос гадна улс орны эдийн засаг дахь аж үйлдвэржилтийн түвшинг нилээд гол үзүүлэлт болгон авдаг.

Говьсүмбэр аймгийн аж үйлдвэрийн салбарт “Шивээ-Овоо” –ийн нүүрсний уурхайн олборлосон хүрэн нүүрс дийлэнх хувийг эзэлдэг. Ордын геологийн нөөц нь тэрбум тонн бөгөөд үүнээс нарийвчилсан хайгуулаар тогтоогдсон үйлдвэрлэлийн нөөц нь 600 сая тонн, жилдээ дунджаар 2 сая тонн нүүрс олборлодог, хүрэн нүүрсний орд газар нь ойролцоогоор 300 жилийн нөөцтэй. Иймд манай аж үйлдвэрийн салбарын өсөлт, бууралт Шивээ-Овоогийн уурхайтай салшгүй холбоотой юм.

Говьсүмбэр аймаг нь Монгол улсын отгон аймаг тул хүн ам цөөнтэй, эдийн засгийн зах зээлийн багтаамж бага байдагтай холбоотойгоор барилга, худалдаа, үйлчилгээний салбарын хөгжил төвийн бүсийн аймгуудтай харьцуулахад удаавтар байна.

Гэсэн хэдий ч Шивээ-Овоо нүүрсний орд газар болон хойд, өмнөд хилийг холбосон хатуу хучилттай авто зам, төмөр замыг түшиглэн, жижиг дунд үйлдвэр, барилга болон худалдааны салбараа дэмжиж ажиллах нь бүс нутгийн хөгжилд Говьсүмбэр аймаг манлайлах үүрэг гүйцэтгэх боломжийг бий болгох нь гарцаагүй юм.

Ашигласан материал

1. Аймгийн эдийн засаг нийгмийн байдлын танилцуулга 2000-2017 он
2. 2017 оны мэдээ, судалгаанууд
3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөр
4. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэл
5. Статистикийн мэдээллийн лавлах www.1212.mn
6. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын танилцуулга

Хаяг : Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс

Утас : 7054-3222, 7054-3017

Е-майл : govisumber@nso.mn

Вэб хаяг: govisumber.nso.mn